



**МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 225

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 4.5 дахь заалт, “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолын 1, 4 дэх заалт, “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 4.1, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг хянан хэлэлцээд **ТОГТООХ** нь:

1. Дундговь аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын салбарын бодлогын хэрэгжилт, хүний нөөц, дотоод хяналт шалгалт, хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Газар, газрын хэвлий, түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт, хөрсний доройтол /цөлжилт/, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Усны нөөцийн ашиглалт, хамгаалалт, ойн бодлого, төрийн бус байгууллага, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Орчны бохирдол, химийн хорт бодис, байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Мэдээллийн сан, байгаль орчны төлөв байдал, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Аялал жуулчлал, гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Биологийн төрөл зүйл, тусгай хамгаалалттай газар нутаг, судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагчийн албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар хавсралт ёсоор тус тус батлахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Н.Гантулга/-д зөвшөөрсүгэй.

2. Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолт тус бүрийг албажуулах, баталж мөрдүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллахыг Ажлын алба /Б.Алтанзул/-нд даалгасугай.

ТАЗ тогтоол 2019


19000258

3.Зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтыг эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь салбар зөвлөл /Ц.Эрдэнэсүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Дундговь аймгийн Байгаль орчин, аялал
жуулчлалын газар

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал
жуулчлалын салбарын бодлогын
хэрэгжилт, хүний нөөц, дотоод хяналт
шалгалт, хяналт-шинжилгээ үнэлгээ
хариуцсан ахлах мэргэжилтэн

Дэс түшмэл, ТЗ-6

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар
баг, Буяннэмэхийн өргөн чөлөө 1-105 тоот

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих,
мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Байгаль
орчин, аялал жуулчлалын газрын даргын өмнө хариуцна.